



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 04 сарын 15 өдөр

Дугаар А/30

Мандалговь

Шатрын анхан шатны мэдлэг олгох  
сургалт зохион байгуулах тухай

Хүүхдийн эрхийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 15 дугаар зүйлийн 15.1.4, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, сангийн сайдын 2022 оны 01 дүгээр сарын 31-ны өдрийн "Аргачлал, зардлын норматив батлах тухай" А/23, 27 тоот хамтарсан тушаалын 3 дугаар хавсралт, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын даргатай байгуулсан байгууллагын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 4 дүгээр зүйлийн 4.8 дах заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хүүхэд багачуудын дунд шатрын спортыг сурталчлан дэлгэрүүлэх, тэдний авьяас билгийг нээн хөгжүүлэх зорилгоор "Шатрын анхан шатны мэдлэг олгох" сургалтыг 2022 оны 04 дугаар сарын 16-ны өдөр зохион байгуулсугай.
2. Сургалтын хөтөлбөрийг 1 дүгээр, төсвийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.
3. Үйл ажиллагаанд шаардагдах 2,795,000 (Хоёр сая долоон зуун ерэн таван мянга) төгрөгийн зардлыг Урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг нягтлан бодогч (С.Чинбат)-д зөвшөөрсүгэй.
4. Тушаалын хэрэгжилтийг хангаж, үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг Хүүхдийн хөгжил, оролцоо хариуцсан мэргэжилтэн (Л.Мөнхсарнай)-д үүрэг болгосугай.
5. Үйл ажиллагааны хэрэгжилтэнд хяналт тавьж үр дүнг 2022 оны 04 дугаар сарын 25-ны өдрийн дотор даргын дэргэдэх зөвлөлд танилцуулахыг мэргэжилтэн (Л.Мөнхсарнай)-д даалгасугай.


ДАРГА



Ц. ГАНЗОРИГ

482201059

Дундговь аймгийн Гэр бүл, хүүхэд,  
залуучуудын хөгжлийн газрын даргын  
2022 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн  
А/30 дугаар тушаалын 01 дугаар хавсралт



## ШАТРЫН АНХАН ШАТНЫ МЭДЛЭГ ОЛГОХ СУРГАЛТЫН УДИРДАМЖ

### Сургалтын зорилго:

Хүүхэд багачуудын дунд шатрын спортыг сурталчлан дэлгэрүүлэх, тэдний авьяас билгийг нээн хөгжүүлж, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэхэд оршино.

### Сургалтанд оролцогчдын насны ангилал:

Аймгийн төвийн ЕБС-ийн 1-5 дугаар ангийн 450 сурагч

### Сургалт зохион байгуулах хугацаа, газар:

2022 оны 04 дүгээр сарын 16-ны өдөр Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын Их танхимд

### Сургалтын хуваарь:

| № | Цаг         | Сургууль                          | Хүүхдийн тоо | Сэдэв                                                                                                                                                                                     |
|---|-------------|-----------------------------------|--------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 1 | 09:00-11:00 | Эрдмийн далай цогцолбор сургууль  | 150          | <ul style="list-style-type: none"><li>➢ Ноён, бэрс, тэрэгний нүүдэл-30 минут</li><li>➢ Тэмээ, морь, хүүний нүүдэл-40 минут</li><li>➢ Шатар тоглож сурахын ач холбогдол-50 минут</li></ul> |
| 2 | 11:00-13:00 | Говийн ирээдүй цогцолбор сургууль | 100          |                                                                                                                                                                                           |
| 3 | 14:00-16:00 | Хүмүүнлэг сургууль                | 100          |                                                                                                                                                                                           |
| 4 | 16:00-18:00 | Мандал сургууль                   | 100          |                                                                                                                                                                                           |

### Сургалтаас гарах үр дүн:

- Бага ангийн хүүхдүүд шатрын спортыг сонирхох, цаашид тоглож сурах сэдэл төрүүлэх
- Шатар тоглох нь хүүхдийн төлөвшил, хүмүүжил, хөгжилд өндөр ач холбогдол үзүүлнэ.
- Шатар ой тогтоолт сайжруулна
- Оюуны чадварыг нэмэгдүүлнэ

Дундговь аймгийн Гэр бүл, хүүхэд,  
залуучуудын хөгжлийн газрын даргын  
2022 оны 4.1 дүгээр сарын 15 ний өдрийн  
11.0 дугаар тушаалын 03 дугаар хавсралт



ШАТРЫН АНХАН ШАТНЫ МЭДЛЭГ  
ОЛГОХ СУРГАЛТЫН ТӨСӨВ

| №        | Зардлын зүйл             |         | Оролцогчдын тоо | Хэмжих нэгж | Өртөг  | Нийт /төгрөг/ |
|----------|--------------------------|---------|-----------------|-------------|--------|---------------|
| 1        | Сургалтын хэрэглэгдэхүүн | Бал     | 450             | тоо         | 1,500  | 675,000       |
|          |                          | Мандат  | 450             | тоо         | 1,000  | 450,000       |
| 2        | Цайны зардал             | Цай     | 450             | тоо         | 500    | 225,000       |
|          |                          | Сэндвич | 450             | тоо         | 2,500  | 1,125,000     |
| 3        | Сургагч багшийн хөлс     |         | 8               | цаг         | 40,000 | 320,000       |
| Нийт дүн |                          |         |                 |             |        | 2,795,000     |